



**ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНД ЦАХИМ ХАРИЛЦААГ АШИГЛАХ ТУХАЙ
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦЫГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалтад Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах асуудлыг Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэхээр, Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтад зааснаар Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц нь Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа тул Улсын Их Хурал заавал соёрхон батална.

Өөрөөр хэлбэл, уг конвенц нь "аливаа харилцаа, эсхүл гэрээг цахим хэлбэрээр үйлдсэн гэсэн ганцхан үндэслэлээр түүний хучин төгөлдөр байдлыг, эсхүл нэхэмжлэлийн шаардлагыг үүгүйсгэж болохгүй" гэж заан цахим болон цаасан суурьтай мэдээллийг эрх зүйн ижил тэнцүү чадамжтай байдлыг хадгалах, цахим гарын үсэг болон ердийн гарын үсгийн ижил тэнцүү нөхцөлийг тогтоох, цахим баримт бичгийг хадгалах, цахим харилцааг илгээх, хүлээн авах, гэрээ байгуулах автоматжуулсан мэдээллийн системийн ашиглалтын талаарх зохицуулалт нь Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоохоор байна.

Монгол Улсын цахим хэлбэрээр гэрээ хэлцэл хийх талаарх хууль, эрх зүйн өнөөгийн харилцааг Иргэний хуулийн 42¹ дүгээр зүйлд цахим хэлбэрээр хийх хэлцлийн тухай, 43 дугаар зүйлийн 43.2.4 дэх заалтад цахим хэлцлийг тоон гарын үсгээр баталгаажуулах тухай, 196 дугаар зүйлийн 196.1.8 дахь заалтад цахим хэлбэрээр гэрээ хийх болон түүнд тоон гарын үсэг зурах тухай зохицуулалтууд болон Цахим гарын үсгийн тухай хуулиар зохицуулж байна.

Монгол Улсын дээр дурдсан хууль, эрх зүйн зохицуулалт нь цахим баримт бичгийн эрх зүйн үндсийг тодорхойлоогүй, цахим баримт бичгийг цаасан суурьтай баримт бичигтэй ижил тэгш хүлээн зөвшөөрөөгүй, и-мэйл, компьютерийн файл, гар утасны богино үсэгт мэдээ (мессеж), мэдээллийн сангийн цахим өгөгдлийг нотлох баримт, хууль зүйн чадамжтай баримт гэж тодорхойлоогүй болно.

Мөн Цахим гарын үсгийн тухай хуулиар олон улсын жишгийн дагуу ердийн болон баталгаат гэсэн цахим гарын үсгийн харилцан ялгаатай 2 хэлбэрийн зохицуулалт тодорхой тусгагдаагүй, тоон газрын үсгийн зохицуулалт давамгайлсан, олон улсын шинжтэй гэрээ, хэлэлцээр, харилцааны шаардлагыг бүрэн хангаагүй болно.

Түүнчлэн, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын худалдааны түгээмэл хэлэлцээрүүдэд, тухайлбал, Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц (Нью-Йорк, 1958), Бараа худалдах-худалдан авах тухай НҮБ-ын конвенц (CISG) зэрэг баримт бичгүүдэд заасан зарим шаардлагууд нь цахим харилцааг өргөнөөр ашиглах явдалд саад тогтор болох талтайг ЮНСИТРАЛ-аас гаргасан илтгэлд дурдсаны дээр Монгол Улсын цахим орчны харилцааны зохицуулалтыг олон улсын зохицуулалттай уялдуулан нийцүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 2005 оны 60/21 дүгээр тогтоолоор баталсан Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай конвенцыг соёрхон батлах нь зүйтэй гэж үзэж байна.

2.Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын 16 дугаар зүйлийн 1-д “Энэхүү конвенц нь 2006 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс 2008 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл Нью-Йорк дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд бух улс гарын үсэг зурахад нээлттэй.” гэж заасны дагуу уг конвенцид гарын үсэг зурах боломжит хугацаа нь 2008 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөр дуусгавар болсон.

Иймд Олон улсын гэрээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт “Заавал соёрхон батлах олон талт олон улсын гэрээнд гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, эсхүл гарын үсэг зурах шаардлагагүй бол тухайн олон талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, энэ зүйлийн 10.1-д заасны дагуу тухайн хүчин төгөлдөр олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох саналыг хэлэлцүүлэхдээ хамт хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцид нэгдэн орох саналыг уг конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хамт хэлэлцүүлж, батлуулахаар боловсруулна.

Уг конвенцоор дараах харилцааг зохицуулсан. Үүнд:

1.Конвенцын 1 дүгээр зүйлд талуудын ядаж нэг нь оролцогч улсад оршин байгаа газартай байх шаардлагын талаар;

2.Конвенцын 3 дугаар зүйлд энэхүү конвенцын заалтуудыг хэсэгчлэн буюу тохируулан хэрэглэх, эсхүл хэрэглэхээс татгалзах уян хатан нөхцөлийг талуудад олгох талаар;

3.Конвенцын 8 дугаар зүйлд цахим хэлбэрээр үйлдсэн гэсэн ганцхан үндэслэлээр аливаа харилцааны хууль зүйн хүчинтэй байдлыг үгүйсгэхгүй байх талаар;

4.Конвенцын 9 дүгээр зүйлд харилцан ялгаатай улсуудад оршин байгаа газар бүхий талуудын хооронд солилцсон цахим харилцааны баримт бичгүүд, тэдгээрийг баталгаажуулсан цахим гарын үсгийг цаасан суурьтай баримт бичиг болон түүнд хэрэглэсэн ердийн гарын үсэгтэй хууль эрх зүйн хувьд ижил тэнцүү байх нөхцөлийг тогтоох, 10 дугаар зүйлд цахим харилцааны илгээх, хүлээн авах цаг хугацаа, оршин байгаа газрын талаарх зохицуулалт;

5.Түүнчлэн конвенцын 11 дүгээр зүйлд санал гаргах дуудлага, 12 дугаар зүйлд автоматжуулсан мэдээллийн систем, түүний дотор хүний оролцоогүйгээр хэлэлцээрт хариу өгөх системийн зохицуулалт, 14 дүгээр зүйлд автоматжуулсан мэдээллийн системтэй харьцахад гаргасан алдааг засварлах боломжийг олгох талаар, ЮНСИТРАЛ-аас өмнө нь боловсруулсан цахим худалдааны болон цахим гарын үсгийн загвар хуулиар тодорхойлсон технологийн үл ялгаварлах, төвийг сахих болон үйл ажиллагааны тэгш байдлын зарчимтай холбоотой харилцаа.

Мөн тус конвенцод олон улсын гэрээ хэлбэрээр 7+18 улс нэгдэн орж, 2 улс элсэж орохоо илэрхийлсэн, дотоодын загвар хууль хэлбэрээр 15 улс хэрэглэж байгаа бөгөөд бус нутгийн 2 байгууллага (ASEAN, ESCAP) одоогийн байдлаар хүлээн зөвшөөрөөд байна.

Энэхүү конвенцод нэгдсэнээр гишүүнчлэлийн татвар байхгүй тул аливаа улс ямар нэг санхүүгийн үүрэг хүлээхгүй бөгөөд тус конвенцыг төлөөлөх байгууллагыг дотооддоо байгуулах шаардлагагүй, түүнчлэн түүний хэрэгжилтийн талаар ямар нэг тайлан, илтгэл гаргах шаардлага тавигдахгүй болно.

Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах нь худалдааг хөнгөвчлөх, оролцогч талуудын шууд болон шууд бус зардлыг багасгах, хил дамнасан цаасгүй харилцаа, экспорт, олон улсын худалдааг дэмжих хамгийн оновчтой, түргэн шуурхай арга зам юм.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцыг соёрхон батлах тухай заалт бүхий нэг зүйлтэй байна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар олон улсын худалдааны харилцааг хөнгөвчлөх, хил дамнасан цаасгүй харилцааг дэмжих, цахим орчны эрх зүйн орчныг сайжруулах замаар дотоодын болон экспорт, олон улсын худалдааны харилцааг дэмжих, эдийн засаг, нийгмийн харилцааны таатай орчин бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй болно.